



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/223

Хэрлэн сум

**А.Ганбаатард буцалтгүй
тусламж олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн иргэн А.Ганбаатарын өргөдлийн дагуу ар гэрийн гачигдалд 500,000 (таван зуун мянга) төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2.Буцалтгүй тусламжид шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэгийн зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ